



## Шинжээчийн тайлан

**Байгууллагын нэр:** ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Хувцасны дизайн

**Индекс:** D021202

Шинжээчийн баг:

Ахлагч:	Д.Энхцэцэг	МУБИС-ийн Багшийн сургуулийн дэд профессор
Гишүүд:	Б.Сэргэлэн	ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн дизайны салбарын дэд профессор
	А.Цэрэннадмид	Судлаач

Он сар өдөр: 2022.12.25

## Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хувцасны дизайн Fashion design	
Индекс	D 021202	
Шинжээчид	Д.Энхцэцэг- МУБИС-ийн Багшийн сургуулийн дэд профессор Б.Сэргэлэн- ШУТИС-ийн ҮТС-ийн дизайны салбарын дэд профессор А.Цэрэннадмид- Судлаач	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022-12-15	Сургуулийн орчинтой танилцах
		Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
		Оюутнуудтай уулзах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах
	2022-12-16	Ажил олгогчдын төлөөлөлтэй уулзах
Багш нартай уулзах		
Урьдчилсан дүгнэлтийг танилцуулах		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль нь 2000 онд “ЮБЛ” ХХК-ны захирал Ю.Болдын санаачилга, хөрөнгө оруулалтаар “ОД” ДУДТДС нэртэйгээр байгуулагдсан. 2010-2011 оны хичээлийн жилээс ИЗОУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, 2014-2015 оны хичээлийн жилд ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургуулийн статусаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2000-2001 оны хичээлийн жилд Хувцас дизайны тэнхим одоогийн Дизайны тэнхим байгуулагдаж хувцасны дизайн мэргэжлээр элсэлт авч эхэлсэн. 2004-2022 оныг хүртэл 18 удаагийн төгсөлт хийж 131 дизайнер бэлтгэн гаргасан байна.

Тус сургуульд техникийн ухааны доктор /Ph.D/ профессор Ц.Нямжав, боловсрол судлалын ухааны доктор /Sc.D/ профессор Ц.Цэвээн, /Ph.D/ профессор Г.Мэндээ, /Ph.D/ дэд профессор Д.Дарьсүрэн, мастер багш Г.Батмөнх, МУ-ын зөвлөх инженер Л.Бат-Аюуш нар тус сургуулийн залуу боловсон хүчин нарт зөвлөгөө өгч чиглүүлэн ажиллаж байна.

**Хувцасны дизайн хөтөлбөрийн зорилго:** Монгол улс болон олон улсын загварын хөгжил, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй онол арга зүйн мэдлэг, практик чадвар, зохион бүтээх арга барилыг эзэмшсэн, өөрийгөө хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй, түүх соёлоо түгээн дэлгэрүүлэгч, судлаач уран бүтээлч мэргэжилтэнг бэлтгэхэд оршино.

**Хувцасны дизайн хөтөлбөрийн зорилт:**

1. Эх хэл, түүх соёлоо эрхэмлэн дээдлэгч, соёлын өв үндэсний уламжлалаа өвлөн авч, түгээн дэлгэрүүлэгч байх
2. Дэлхийн болон монголын хувцасны соёл түүхийг судлан шинжлэх, уламжлал шинэчлэлийг бүтээлдээ тусгах ур чадварыг эзэмшүүлэх
3. Хувцасны загвар зохион бүтээгчийн эзэмшсэн байх ёстой суурь онолын мэдлэг, практик ур чадварыг эзэмшүүлж, мэргэжилдээ дур сонирхолтой болгох
4. Хувцасны загвар зохион бүтээхдээ уран сайхны талаас болон зохион бүтээлт, материал судлал, хийц технологийн судалгаа шинжилгээнд тулгуурлан, уран бүтээлдээ тусгах чадвартай урлаг гоо сайхныг мэдэрч, эко нөлөөлөл орчны хэрэглээг хангасан шинэ загвар бүтээдэг болгох
5. Өөрийгөө хөгжүүлэн, шинийг эрэлхийлэгч, бүтээлч сэтгэлгээтэй, шинжлэн судлах, асуудлыг удирдлагын төвшинд шийдвэрлэх чадвартай, хариуцлагатай, мэргэжлийн болон харилцааны ёс зүйтэй байх
6. Багаар ажиллах, харилцах, хамтран суралцах чадвартай, нийгмийн амьдрал, байгууллагын зүй тогтол, эрх чөлөө, үнэт зүйлс, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэгч
7. Хувцас дизайныг өргөн утгаар нь ойлгож системтэйгээр сэтгэх, дизайны мэргэжил, дизайнер хүний ажил үүргийг ухамсарлан, хувцасны дизайнер хүний мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах чадамжтай болгох.
8. Дизайны болон үйлдвэрлэл, бизнес, байгууллагын хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, бүтээх, удирдан манлайлах, гадаад хэлний мэдлэг, оюуны өмчийг бүтээн туурвих, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах, бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх арга зүй, аргачлал, аргыг мэддэг үйл, ажиллагаандаа хэрэглэдэг, асуудал шийдвэрлэх чадвартай болгох.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- 2022 оны үндэсний статистикийг судалгаа
- МУ-ын хууль 2019.06.06-ы өдрийн “Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” тогтоол, МУ-ын их хурлын 2020.05.13-ны өдрийн 52-р дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого дээр хөнгөн үйлдвэрийн салбарын эрэлтийг тодорхойлсон гэж үзжээ.
- БШУЯ-ны Дээд боловсролын статистик үзүүлэлтээс төгсөгчдийн судалгааны харьцуулалтыг хийжээ.
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийгдсэн байна.
- Ирээдүйн чиг хандлагын STEEP шинжилгээ хийсэн байна.

##### Онцлог зүйл:

- Хувцас дизайн хөтөлбөрөөр 2017 оноос хойшхи суралцагчид, төгсөгчдийн тоон харьцуулсан үзүүлэлт хийсэн.
- Ирээдүйн чиг хандлагын STEEP шинжилгээ хийсэн.
- Монголын ШУТИС-ҮТС, МУБИС, СУИС-ийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээ хийсэн.
- Мөн өөрийн хөтөлбөрөө ДУДТС-ийн ОХУ-ын А.Н.Косыгины нэрэмжит Орос улсын их сургууль, АНУ-ын СанФранциско хотын Урлагийн академийн Хувцасны дизайн хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж дүгнэжээ.

##### Анхаарах асуудал:

- Судалгаа 1.5, 1.6, 1.9-ийн асуулга болон хэмжээсжүүлэлт тохиромж муутай байгааг анхаарах

**Дүгнэлт:** Хувцас дизайн хөтөлбөрөөр 2017 оноос хойшхи суралцагчид, төгсөгчдийн тоон харьцуулсан судалгаа хийсэн. Ирээдүйн чиг хандлагын STEEP шинжилгээ хийсэн. Монголын ШУТИС-ҮТС, МУБИС, СУИС болон ОХУ-ын А.Н.Косыгины нэрэмжит Орос улсын их сургууль, АНУ-ын СанФранциско хотын Урлагийн академийн Хувцасны дизайн хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж дүгнэжээ. Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан боловсруулагдсан байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Дотоодын болон гадаадын ижил мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөрүүдийг харьцуулан анализ хийхдээ зөвхөн сургалтын төлөвлөгөө бус сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэлт гэх мэт хөтөлбөрийн элементүүдийг бүхэлд нь авч үзэхийг зөвлөж байна.

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Тухайн хөтөлбөрийн зорилго PEO, хөтөлбөрөөр суралцагчдын хүрэх үр дүн PLO-уудын матрицыг хийжээ.
- Хувцасны дизайн хөтөлбөрийн хичээлүүдийн сургалтын арга зүйг суралцахуйн үр дүнгүүдийн хоорондын хамаарлыг ITUA загвар ашиглан тодорхойлсон байна.
- Эрдмийн зөвлөл, хөтөлбөрийн хороо болон тэнхмийн хурлын холбогдох протоколууд, шат шатны хурлын шийдвэрүүд, дүрэм журмын гарын авлага

**Анхаарах асуудал:**

- PLO болон бүх хичээлүүдийн хоорондох хамаарлын матрицыг ажиглахад дунджаар нэг хичээл нь PLO-ийн 5-6 мэдлэг, ур чадварт хүрэхээр хийгдсэн байгаа боловч, хичээл бүрийн харгалзах ур чадваруудын тоо харилцан адилгүй байна.

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн зорилго PEO нь байгууллагын эрхэм зорилго, зорилт PLO, холбогдох мэргэжлийн салбарын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн PLO болон CDIO сургалтын арга зүйг хольж ойлгох хандлага байгаад анхаарч ажиллах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- “Хувцасны дизайн” хөтөлбөрөөр төгсөгчдийн загвар
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчилсэн дараах бичиг баримтууд

- 2014 онд БШУ сайдын 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаал “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, БШУ сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ыг үндэслэн “Хувцасны дизайн” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн.
- 2018 онд ДУДТДС-ийн эрдмийн зөвлөлийн 2018 оны 06 сарын 05-ны өдрийн хурлын шийдвэр, ДУДТДС-ийн 2018 оны 06 сарын 25 өдрийн 27 тоот захирлын тушаалын дагуу “Үр дүнд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх”, БСШУС-ын сайдын 2018 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/533 тоот тушаалаар баталсан “Үр дүнд суурилсан боловсрол” хөгжүүлэх бодлогын баримт бичгийг тус тус үндэслэн “Хувцасны дизайн” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчилсэн.
- 2022 онд БШУЯ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/348 тушаалын хавсрат “дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 сарын 09-ний өдрийн А/160 тушаал “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” үндэслэн “Хувцасны дизайн” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн

#### **Онцлог зүйл:**

- Хувцасны дизайн хөтөлбөрийн хичээлүүдийн сургалтын арга зүйг суралцахуйн үр дүнгүүдийн хоорондын хамаарлыг ITUA загвар ашиглан тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн төлөвлөлтөд SWOT шинжилгээ хийсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Үр дүнд суурилсан боловсролын сургалтын CDIO арга зүйн хүрээнд хичээлийн хөтөлбөрүүдээ тасралтгүй сайжруулах.

**Дүгнэлт:** Сургалтын төлөвлөгөө /2014, 2018, 2022/, хичээлийн хөтөлбөрүүд нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлага /CLO/-ын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй CDIO, сургалтын үнэлгээг тогтмол сайжруулдаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг нэмэгдүүлэх

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагаанд хийсэн PDCA шинжилгээ
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн шинэчилсэн, холбогдох журмууд
- Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалт
- Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүд болон лекц, семинар, дадлагын харьцаа
- Суралцагчдын цагийн ачааллын судалгаа
- <http://main.xcloud.mn> дотоод удирдлагын мэдээллийн систем,
- Бүхий л төрлийн дадлагууд хийх бааз газруудын нэр, гэрээ
- Байгууллагуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаа, оюутны дадлага хийсэн байдалд өгөх байгууллагын үнэлгээ, дадлага хийсэн оюутнуудаас авсан мэдлэг, чадвар, хандлагын судалгааг (2016 оноос хойшхи)

#### Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог схемчлэн дүрсэлсэн нь /схем 2.1/
- Оюутны цагийн ачааллыг хичээлийн жилээр, улирлаар, долоо хоногоор тооцоолсон байна.

#### Анхаарах асуудал:

- 2.11 судалгааны хүснэгт, 2.1 судалгааны график нь дүгнэлт хийхэд тохироц муутай судалгаа байна.

**Дүгнэлт:** Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн харьцаа боломжийн, хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог схемчлэнээс үзэхэд давхардалгүй, харилцан уялдаатай, тасралтгүй хөгждөг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### Зөвлөмж:

- Аливаа судалгааны асуулга нь юуны өмнө найдвартай, тохироцтой эсэхийг тогтоосны үндсэн дээр тухайн судалгаа авах, ингэснээр үнэн бодитой үнэлгээ дүгнэлт гардгийг тооцоорой.



## 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### Илрэл нотолгоо:

- Зураг судлалын, үйлдвэрлэл технологийн, үйлвэрлэлийн технологи, зохион байгуулалтын, зураг төслийн дадлагын удирдамж, баримт бичгүүд
- Мэргэжлийн суурь хичээлүүдийн болон мэргэжлийн хичээлүүдийн стандарт, хөтөлбөр
- Сурах бичиг, гарын авлага

### Онцлог зүйл:

- Нэгж хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар нь үр дүнд суурилсан сургалтын арга зүйтэй хэрхэн уялдаж буй хамаарлыг харуулжээ.

### Анхаарах асуудал:

- Багш суралцагчдыг холбох дотоод удирдлагын мэдээллийн системдээ тасралтгүй хөгжүүлэлт хийх.

**Дүгнэлт:** Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, нэгж хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар нь үр дүнд суурилсан сургалтын арга зүйтэй уялдаатай, суралцагч төвтэй, суралцагчдыг холбох дотоод удирдлагын мэдээллийн систем ашигладаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### Зөвлөмж:

- Мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглалтыг нэмэгдүүлэх

## 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### Илрэл нотолгоо:

- Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх журам
- Суралцагчийн үнэлгээ болон үнэлгээний заалт
- Суралцагчийн үнэлгээний загвар
- Оюутны дүнгийн голч /вэбд/
- Үйл ажиллагаа болон үнэлгээний матриц
- Нэгж хичээлүүдийн дадлагаар олгох үр дүнг үнэлэх Рубрик
- Нэгж хичээлүүдийн дүн шинжилгээ
- 2.3- дэд шалгуурт хийсэн SWOT шинжилгээ

- Хувцасны дизайн зохиомжийн үндэс хичээлийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ (2016 оноос хойшхи)

**Анхаарах асуудал:**

- Дадлага хийх байгууллагууд болон төгсөгчид ажилллах байгууллагуудтай хамтран ажиллах.

**Дүгнэлт:** Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг системтэй, үнэлгээний арга зүйгээ тасралтгүй сайжруулдаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

**3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл
- Багш нартай уулзаж, хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл
- Сургалт явуулж буй орчин нөхцөл

**Онцлог зүйл:**

- Боловсролын үйл ажиллагаа нэг дор төвлөрсөн барилгын цогцолбортой
- Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургуулийн өргөтгөлийн барилга /эскиз зураг/ Улаанбаатар хот 2019 он
- Багш нар өөрсдийн гэсэн YouTube цахим хуудастай болж, өөрийн бэлтгэсэн e-контентыг нээлттэй хүргэж байна.
- Дүрс судлал зохиомжийн урлан № 3-203, Зураг төслийн автоматжуулалт, Компьютерын лаборатор № 2-305, Оёдлын технологийн лаборатори №2-306, Сүлжмэлийн технологийн лаборатори №2-307, Нүүр будалт имидж бүрдүүлэлтийн урлан №2-308, Лекцийн танхим №2-101

**Анхаарах асуудал:**

- Сургуулийн гадаад орчинд замын гарцын тэмдэг байршуулах

- Сургууль болон оюутны дотуур байр хоорондох замын гэрэлтүүлэг хийх

**Дүгнэлт:** ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС нь өөрийн өмчийн барилга байгууламжид өөрийн нөөц бололцоонд тулгуурлан сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Мэргэжлийн хичээлийн лабораториуд, анги танхим шаардлага хангасан стандартад нийцсэн байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Гал тогоонд технологийн карт мөрддөг байх
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө гаргаж мөрдөх

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн талаар багш, төгсөгчид, оюутнуудтай хийсэн уулзалт, тэмдэглэлүүд
- ИЗОУИС-ийн Харьяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Сургуулийн захирлын тушаал 2021.04.01 дугаар 37
- Хичээлийн гурван байр, Оюутны дотуур байр цогцолбортой

**Онцлог зүйл:**

- Фото студийн лабораторийг түшиглэн онлайн хичээл бэлтгэх орчныг бүрдүүлсэн /№2-304 өрөө/
- Сургалтын материаллаг бааз, багш оюутнуудад ажиллах суралцах орчныг бүрдүүлж өгсөн.
- Өнгө судлал, Дүрс судлалын урлантай.
- Оюутны дотуур байранд номын сан 24 цагаар ажилладаг.
- Сургуулийн орчинд оюутан сурагчдын бүтээлийг байршуулсан.
- Мэргэжлийн VokeCAD- хувцасны хувцасны үлгэр, эсгүүр зурах, Tajima -хатгамал хийдэг, Marvelous-хувцасны загвар 3D гаргадаг программуудыг эзэмших эрхтэй.

**Дүгнэлт:** ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС нь Лицензтэй программуудыг ашиглаж технологид суурилсан үйлдвэр, аж ахуй нэгжид ажиллах ур чадварыг олгож байна. Цахим сургалтын анги шинээр нээн сургалтдаа ашиглаж эхэлсэн нь цахим сургалтыг хөгжүүлэхэд томоохон алхам болж өгсөн байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Зөвлөмж:**

- Макет урлаг, Технологийн лаборатори №102 өрөөнд байрших тоног төхөөрөмжийн дээр аюулгүй ажиллагааны зааварчилгааг байршуулах.
- Сүлжмэлийн сүлжих машин болон кеталь машин хоёрын гейч технологийн хувьд хоорондоо таарч байх ёстой байдаг.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн номын сангийн орчин
- Өөрийн үнэлгээний тайлан
- Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургуулийн Номын сангийн хурлын шийдвэр /2022.12.08/
- Номын сангийн үйл ажиллагааны тайлан
- ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн Номын сангийн хүрээнд зохиогдох Номын баяр 2021 өдөрлөгийн удирдамж /2021.09.21/

### **Онцлог зүйл:**

- Цахим хичээлд зориулсан дижитал номууд, хичээлийн материалууд сайн
- Хувцас загварын чиглэлийн гадаад дотоодын ном сурах бичиг сайн
- Номын захиалга, жагсаалт баримт бичиг баталгаажуулалт сайн

**Дүгнэлт:** Гадаад хэл дээрх ном сурах бичгийн тоо хүрэлцээтэй, Багш нар мэргэжлийн хичээлийн удирдамж гарын авлагыг гаргаж оюутнуудын хүртээл болгосон.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ИЗОУИС-ийн дүрэм журам, захирлын тушаал, сургалтын журам /багш ажилчдыг дэмжих журам, хөдөлмөрийн дотоод журам, багшийн ажлын үнэлгээний журам/
- ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн захиргааны зөвлөлөөс багш, ажилтанд үүрэг даалгаврыг жил бүр өгдөг. Багш нарын богино уртын төлөвлөгөө боловсруулсан үндсэн дээр жилийн төлөвлөгөө гардаг. Багш тус бүр сар бүр тайлан бичдэг, үр дүнг сургуулийн удирдлага хянаж /сургалтын бодлого зохицуулалтын алба/ үр дүнг танилцуулдаг.
- Санал хүсэлтийг шийдвэрлэсэн хүснэгт гаргасан /хамрагдах хугацаанд жишээ нь 2021-2022 онд 65 санал хүсэлт гарснаас 59 шийдвэрлэсэн.
- Дизайны тэнхимийн хурлын протокол 2017.05.28, 2018.08.28. 2021.08.25 /нийт 8 удаа протокол хөтөлсөн/
- Тэнхимийн урт /5 жил/, богино /1жил/ /хугацааны тайлангийн дүгнэсэн хүснэгт /2019-2020 онд урт хугацааны дүгнэлт 83%, богино хугацаанд 86%/

### **Онцлог зүйл:**

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн хяналт сайтай, санал гомдлыг хүлээн авч хурдан шийдвэрлэдэг. График үзүүлэлтийг хавсаргасан.
- Тэнхимийн ажлыг богино /1 жил/, урт /5 жил/ төлөвлөгөө боловсруулж, тайлан гаргадаг.

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн хувьд бусад их дээд сургуультай ижил төстэй боловч багшийн ачаалал нь ИЗОУИС-ийн стандартыг дагадаг нь хэт өндөр ачаалалтай бөгөөд тайланг сар бүр гаргадаг нь багшийн эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх боломжийг багасгаж байна.

**Үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан

### **Зөвлөмж:**

- Багш нарын тайланг улирал тутамд гаргахаар тусгах /сар сардаа тайланг гаргахад цаг алдах магадлалтай/.
- Багш нарын ачааллыг эргэн харах /нийт ачаалал 30 кр/А, В, С/, А цаг зэрэглэлээс хамааран 16-18 кр хооронд байна.

**Шаардлага:** Бусад их сургуулийн багшийн ажлын ачааллыг харьцуулан үзэж, ачааллыг бодитойгоор гаргаж, журамд оруулах.

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хамтын ажиллагаатай Алтайский Государственный университет им. И.И.Ползунова /санамж бичиг 2018.08.18/
- Алс дорнодын Сибирийн технологийн сургууль /санамж бичиг 2017/
- ОХУ-ын Барнаулын Алтайн техникийн Их сургууль /санамж бичиг/
- Российская Академия художеств 2018 оны Олон Улсын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулсан.
- Нийгэмд чиглэсэн жил бүр тогтмол явуулдаг 8 үйл ажиллагаа /"Мөрөөдлийн зүг" ЕБС – н ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулдаг наадам, "Эко яан" "Эко тор" төсөл хэрэгжүүлсэн. хот цэвэрлэх аян.../ Төгсөгчдөөс ахисан түвшинд үргэлжлүүлэн суралцсан. Ахисан түвшинд төгсөгчдөөс эргэн суралцах судалгааг гаргасан /15%/, өөрийн төгсөгч болон багш нарыг ахисан түвшинд суралцахад хөнгөлөлт үзүүлдэг.
- ИЗОУИС-ийн төгсөгчдийн холбооны дүрэмтэй, эргэх холбоо сайн.

#### **Онцлог зүйл:**

- Гадаадын болон дотоодын хамтын ажиллагаа сайтай. Багш нарын томилолтын зардал гаргадаг, уралдаан тэмцээнд оролцоход материалын зардал гаргаж дэмждэг.
- Төгсөгчидтэйгээ эргэх холбоо сайн, дадлага хийх, туршлага судлахад хамтран ажилладаг.
- ЕБС-д болон нийгэмд хандсан үйл ажиллагаа ихтэй.
- Хорооны ахмадуудад чиглэсэн үнэгүй зургийн сургалт явуулдаг.

**Дүгнэлт:** Гадаад дотоодын хамтын ажиллагаа хөгжсөн, нийгэмд хандсан найман төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Гадаадын багш, суралцагчдын хамтын ажиллагааны солилцоог идэвхжүүлэх.

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Нэг суралцагчид ноогдох 1 кредитийн зардал 85902,4 төг /2021-2022 онд/
- Сургалтын төлбөр, улсын төсөв /ашиглалтын зардал/, үндсэн бус үйл ажиллагааны орлого, бусад орлогоос төсөв бүрдэнэ.
- Туслах үйл ажиллагааны санхүүжилт 2017-1100000, 2018-1300000, 2019-1600000, 2020-2200000, 2021-3670000 туслах үйл ажиллагааны орлого орсон.
- Боловсролын зээлийн сангаас 2017-105000000, 2018-85500000, 2019-85910000, 2020-103902000, 2021-81950000 бусад орлого 2017-7300000, 2018-10800000, 2019-14270000,

26435000, 2021-56036000 зарцуулалтын тайлан хавсаргасан /удирдлагын зөвлөлийн протокол болон тайлан/.

- Сургуулийн төсөв 5 жилээр хавсаргасан 2019-31984880, 2020онд 30919151, 2021 оны Дизайны тэнхимийн гүйцэтгэл 52860995 төгрөг
- 2019-2020 ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн захирлын тушаал 2021.04.01 №37 шуудан холбооны /интернет/ зардалд 5250000 төг. 2021.12.24 №58 2140000. 2021.02.24 №А/16
- Багш хөгжлийн сургалт зохион байгуулах зардлыг гаргах тухайд, 2021.11.10 №53 Багш хөгжлийн сургаалтанд суух зардал 5000000 төг, 2021.02.10 112 бичиг хэрэг 3250000. Захирлын тушаал 2021.02.10 №15 Сургалтын хэрэглэгдэхүүний зардал 4000000 төг
- Захирлын тушаал 2021.10.15 №50 хөтөлбөрийн тайланд зарцуулагдах төсөв 2443000 төг
- Их засаг олон улсын их сургуулийн захирлын тушаал 2021.02.04№ 09 эрдэм шинжилгээний ажилд эрдмийн зөвлөлийн ажлын үнэлгээний тушаал тус бүр 200000 төгрөг зарцуулах тушаал. 2021.10.02№ 49 эрдэм шинжилгээний ажилд 1700000 төгрөг зарцуулах тушаал, 2021.02,10 №14 эрдэм шинжилгээнд зарцуулах төсөв 12100000 төгрөг.

#### **Онцлог зүйл:**

- Олон талын санхүүжилтийг тусгасан, жил болгоны төсөв, гүйцэтгэлийг хавсаргасан. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулдаг хичээл практикийн зардал тусгагддаг.
- Хөтөлбөрийн тайланд зарцуулагдах төсөв тусгасан.
- Судалгаа шинжилгээнд санхүү төсөвлөгддөг.
- Багш нарын хөгжилд төсөв төсөвлөгддөг.
- Хичээл практикийн зардал тусгагддаг.

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг. Уралдаан тэмцээн, үзэсгэлэнд багш, оюутан оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн чиг хандлага өгөх сургалт 15 удаа зохион байгуулсан, Телевизийн ярилцлага 6, үзэсгэлэн уралдаан тэмцээн 16. Жил бүр "Мөрөөдлийн зүг" ЕБС-н сурагчдад зориулсан Олон улсын уралдаан зохион байгуулдаг. 1-р байранд орсон хүүхэд нь 1-р курстээ 100 хувийн тэтгэлэг авдаг.
- Захирлын тушаалаар /2021.03.10-ны №34/ тайлан гүйцэтгэлтэй холбоотой цалин урамшуулалд 6450000 төг баталсан.
- Захирлын тушаалаар /2021.02.01 №06/ ном сурах бичиг худалдан авах зардал 3000000 төг баталсан.

- Захирлын тушаалаар /2021.12.27 №59/ хөдөлмөр хамгаалах зардал 860000 төг баталсан.
- Мэргэжилдээ сонирхолтой байх сурах орчин бүрдсэн.

#### **Онцлог зүйл:**

- Маркетинг идэвхжүүлэлт сайтай, мэргэжил сурталчлах, элсэгчдэд хандсан үйл ажиллагаа ихтэй.
- Элсэгчдийн бэлтгэлд анхаардаг /үнэгүй зургийн давтлага өгдөг, уралдан тэмцээн зохион байгуулдаг/.
- Сургуулийн хөгжүүлэлтийн зардал төсөвт тусгагдсан.
- Оюутан, багш нарыг эрт идэвхжүүлэх зорилгоор 7:30-8:10 цагийн хооронд үнэгүй “Өглөөний унд” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

**Дүгнэлт:** Маркетинг идэвхжүүлэлт сайн, элсэгчдэд хандсан үйл ажиллагаа ихтэй, суралцагчдын идэвх зүтгэлийг дэмжих тал дээр анхаардаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- <http://hemis.edu.mn>-ийг 2017 онд <http://main.xcloud.mn> болгон хэрэгжүүлсэн. <http://sw.xcloud.mn> /оюутны вэб/, <http://tw.xcloud.mn> /багшийн вэб/, <http://designart.lib4u.net> /цахим номын сан/ -руу шууд орох боломжтой.
- Захирлын тушаал 2021.02.04 №07 ДХШҮЧБА ажлын судалгааны ажлын хөлс 2700000 төг
- 2016 оноос жил бүр багш нарын болон оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл гаргадаг 2020 /1,2/, 2021, 2022
- Багш төгсөгчдийн бүтээлийн каталог 5 жилд 1 удаа хэвлүүлдэг /2017, 2022/
- Элсэгчдэд зориулсан танилцуулга, үйл ажиллагаа байнга явуулдаг.
- Сургуулийн 2-р байранд галерейтай.
- Дизайны мэргэжлийн оюутанд зориулсан уралдаан тэмцээнд тогтмол оролцдог.

#### **Онцлог зүйл:**

- Багш оюутны бүтээлийг уралдаан тэмцээнд оролцоход дэмждэг, санхүүгийн дэмжлэг өгдөг.
- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг хамрагдах хугацаанд 2 удаа хэвлүүлсэн, бүтээлийн каталог 2 удаа хэвлүүлсэн.



**Дүгнэлт:** Хөтөлбөрийн багш, оюутныг эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, төгсөгчдийн холбоотой хамтарч ажилладаг, xcloud системийг ашигладаг, олон нийтэд хандсан мэдээлэл зар сурталчилгаа сайн.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Багшийн вебед зөвлөх оюутныг харагдах цэс нэмэх, өмнөх жилүүдийн дүнг эргэн харах боломжит цэс нэмэх тал дээр анхаарч ажиллах.
- Багшийн лекцийн материал оюутны веб дээр харагддаг тохиолдолд багшийн оюуны өмчийг баталгаажуулах тал дээр ажиллах.

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ИЗОУИС-ийн Харьяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам, 2021 оны 05 сарын 20-ны А/187 тоот Босго оноо тогтоох тухай тушаал, БШУС-ын 2021 оны 08- сарын 02 ны А/272 тоот “Ур чадварын оноог дүйцүүлэн тооцох” тухай тушаалуудаар нийцүүлэн боловсруулсан.
- ИЗОУИС-ийн Гадаадын иргэдийг суралцуулах журам
- Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчээс чадварын шалгалт авах удирдамж БШУ-ын сайдын 2022 оны Жагсаалт батлах тухай А/207 тоот

**Онцлог зүйл:**

- Шинэ элссэн суралцагчийг чиглүүлэх гарын авлагаар хангасан.
